



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

Бөөр хамгаалах үндэсний
стратеги батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1, хүн амд үзүүлэх бөөрний эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний чанар, хүртээмж, эрхзүйн орчныг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. “Бөөр хамгаалах үндэсний стратеги”-ийг нэгдүгээр, “Бөөр хамгаалах үндэсний стратеги”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд дотоодын эх үүсвэрээс гаргах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт 2014 оноос эхлэн тусган санхүүжүүлэх, олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусlamжийн тодорхой хэсгийг чиглүүлэх арга хэмжээ авахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхбат), Санхүү, эдийн засгийн хэлтэс (Д.Дамдиндорж), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга, захирал нарт даалгасугай.
3. Үндэсний стратегийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхбат), мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллахыг Дотрын мэргэжлийн салбар зөвлөл (Б.Цэрэндаш), Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дарга (Д.Бямбадорж) нарт тус тус үүрэг болгосугай.
4. Холбогдох хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, байршуулах, тогтвортой ажиллуулах арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-д даалгасугай.
5. Тус стратегийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлж, хэрэгжилтийн тайланг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт жил бүрийн 7 дугаар сарын 25, 1 дүгээр сарын 25-ны дотор ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтuya)-д үүрэг болгосугай.

САЙД

Н.УДВАЛ

002160

БӨӨР ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ

Нэг. Үндэслэл

1.1 Дэлхий дахинд

Бөөрний өвчин эмгэг нь хүн амын өвчлөл, нас баралтад нөлөөлж байгаа нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлын нэг болж байна. Дэлхийн хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаанд бөөрний архаг өвчин эмгэг, түүний хүндрэл бөөрний архаг дутагдал нь (БАД) дээгүүр байр эзэлж байна. Судлаачдын үзэж байгаагаар Дэлхий дахинд хүн амын жилийн дундаж өсөлт 1.3% байхад бөөрний архаг дутагдлын тохиолдлын өсөлт 7.0% байдаг¹ ба энэ нь хувь хүний эрүүл мэндийн боловсролын түвшин, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжээс шалтгаалж байна. Азийн орнуудад 2 тэрбум хүн бөөрний архаг өвчин эмгэгээр өвчилж байгаагийн дийлэнх нь залуу болон хөдөлмөрийн насны хүмүүс байна².

Хөгжингүй орнуудад наскжилт болон чихрийн шижин нь нийгэм, эдийн засгийн дарамт ачаалал үзүүлдэг бол бага, дунд орлоготой орнуудад бөөрний архаг өвчин, бөөрний архаг дутагдал байдаг байна³. Өндөр хөгжилтэй орнуудын эрүүл мэндийн салбарт хүн амыг эрүүлжүүлэх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж бөөрний архаг өвчин, эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, бүртгэх, хянах асуудлыг цогцоор шийдвэрлэснээр бөөрний архаг дутагдлын тохиолдлыг бууруулсан байна⁴.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас тухайн улс орны төр засаг, төрийн бус байгууллагуудыг энэ чиглэлд үйл ажиллагаагаа нэгтгэн идэвхитэй хамтран ажиллахыг уриалдаг. Жишээ нь: Австрали улсын⁵ хүн амын 3 хүн тутмын 1 нь бөөрний архаг эмгэгээр өвдөх эрсдэлтэй, 25-аас дээш насны хүн амын 7 хүн тутмын 1 нь бөөрний архаг эмгэгийн нэг ба түүнээс дээш шинж тэмдэг, зовиур бүхий байдаг бол өдөр бүр 5 хүний амь насыг аврах зорилгоор бөөрний диализ эмчилгээ болон бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг хийдэг байна. Малайз улсад бөөрний архаг дутагдалтай өвчтөн 1998 онд 1 сая хүн тутамд 68 байсан бол 2006 онд 139, Тайланд улсад 101 байсан бол 304 болж өссөн байна.

Дэлхийн хүн амын бөөрний өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх талаар хүн амын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Бөөр хамгаалах дэлхийн өдөр”-ийг 2006 оноос эхлэн, одоогоор 200 гаруй улс оронд тэмдэглэж байна. Манай оронд 2009 оноос тус өдрийг тэмдэглэж ирсэн.

¹ (ESRD patients in 2004: global overview of patient numbers, treatment modalities and associated trends Nephrology Dialysis Transplantation 2005 20(12):2587-2593; doi:10.1093/ndt/gfi159)

² Vivekanand Jha, Seminars in Nephrology Vol.29, № 5 September 2009

³ Bulletin of the World Health Organization 2008;86:229–237.

⁴ Bulletin of the World Health Organization 2008;86:229–237.

⁵ Австралийн Эрүүл мэндийн үндэсний статистик, Бөөрний архаг эмгэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр

1.2 Монгол улсад бөөрний өвчин эмгэгийн тархалт

Эрүүл мэндийн сүүлийн 10 жилийн үзүүлэлтээр шээс бэлгийн тогтолцооны өвчлөл нь⁶ нийт хүн амын өвчлөлийн шалтгаан дотор гуравдугаар байр, хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн шалтгаан дотор тэргүүлэх байрыг өзэлж, сүүлийн 23 жилд шээс бэлгийн тогтолцооны өвчлөл 10 000 хүн амд тасралтгүй өсөн нэмэгдсээр иржээ.

График 1. Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, 10 000 хүн амд (1990-2012 он)⁷




График 2. Улсын нэгдүгээр төв эмнэлэг (УНТЭ)-т үйлчлүүлсэн бөөрний цочмог дутагдал (N17), бөөрний архаг дутагдалтай өвчтөний тоо (2007-2011 он)⁸



Бөөрний цочмог дутагдал, бөөрний архаг дутагдалтай өвчтөний тоо (график 2) жилээс жилд ихсэж байгаатай холбоотой үзүүлэх тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэж байна.

⁶ Үндэсний эрүүл мэндийн үзүүлэлт 2012

⁷ Үндэсний эрүүл мэндийн үзүүлэлт 1990-2012 он

⁸ УНТЭ-ийн статистикийн мэдээллийн алба

Манай хүн амын дунд бөөрний архаг өвчин эмгэг, түүний эрсдэлт хүчин зүйлс, бөөрний үйл ажиллагааны дутагдлын тохиолдол нэмэгдэж байна⁹. Судалгаагаар 1984 онд 3 эмэгтэйн 1 нь бөөрний архаг пиелонефриттэй байсан бол 2009 онд судалгаанд хамрагдагсдын 38,2%-д бөөрний архаг өвчин эмгэг илэрсний¹⁰ 34% нь бөөрний үйл ажиллагааны дутагдалтай байсан байна. Судалгаанд хамрагдагсдын дунд бөөрний өвчин эмгэгийн эрсдэлт хүчин зүйлс болох цусны даралт ихсэлт 33,2%, чихрийн шижин 4,2%, таргалалт 14, 5%, архаг тамхидалт 16,3%, хөдөлгөөний дутагдал 75,7%, давстай цайны хэрэглээ 81,3%-ийг эзэлж байсан. 2009-2011 онд “Бөөр хамгаалах дэлхийн өдрийг тэмдэглэх” ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 180 хүүхдэд үзлэг хийхэд, тэдгээрийн 46%-д шээсний шинжилгээнд өөрчлөлттэй байсан зэрэг нь бөөрний өвчин эмгэгийн тархалт өндөр байгааг харуулж байна.

ЭХЭМҮТ-ийн статистик мэдээллээс харахад 2000-2005 онд бөөр, дотоод шүүрлийн тасагт бөөрний архаг өвчнөөр хэвтэж эмчлүүлсэн нийт 2885 өвчтөнөөс бөөрний архаг дутагдалтай 62 (2%), үүнээс 44 шинэ тохиолдол, нас барсан 27 (43.5%), гемодиализийн эмчилгээнд 5 (8%) хүүхэд хамрагджээ. 2006-2010 онд ЭХЭМҮТ-д нас барж задлан шинжилгээнд орсон нийт 2263 хүүхдийн 110 гаруйд нь бөөрний цочмог дутагдал оношлогдсон байна. Сүүлийн жилүүдэд тус төвд эмчлүүлж байгаа нярай хүүхдийн дунд /гемодиализ эмчилгээ хийгдэх боломжгүй/ бөөрний цочмог дутагдлын тохиолдол өсөн нэмэгдэж байгаа нь энэ тусlamж үйлчилгээг шинээр нэвтрүүлэх асуудал тулгамдаж байгааг харуулж байна. ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлэг нь улсын хэмжээнд 3-р шатлалын эмчилгээ үйлчилгээ үзүүлдэг байгууллага бөгөөд цаашид хүүхдийн бөөрний өвчин, эмгэгийн тусlamж, үйлчилгээг цогцоор нь үзүүлж, чанарыг сайжруулахад хэвлийн диализийн тусlamж, үйлчилгээг үзүүлэх зайлшгүй шаардлагатай байна¹¹.

1.3 Бөөрний өвчин эмгэгийн үед үзүүлж буй тусlamж, үйлчилгээний өнөөгийн байдал

Дэлхий нийтэд хэвтүүлэн эмчлэх тусlamжаас татгалзаж, хүүхэд насанд нь сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, үлдэцгүй эмчлэх, бөөр хамгаалах, хянах үйл ажиллагааг түлхүү хөгжүүлж байхад манайд ор бүхий эмнэлгийн тусlamж, үйлчилгээг шүтсэн хэвээр байна. Мөн аймаг, дүүргийн эмнэлэгт бөөрний кабинет байдаггүй, бөөрний эмч бэлтгэгдээгүй нь тусlamж, үйлчилгээ догоход суурь нөхцөл болдог. Улсын хэмжээнд бөөрний кабинет 15, бөөрний мэс заслын кабинет 7 байгаа нь ДОХ-ын 28, чих хамар хоолойн 91, мэдрэлийн 88, уламжлалтын 167, эмэгтэйчүүдийн 194 кабинет зэрэг бусад мэргэжлийн кабинеттaiхарьцуулахад бага байна. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт бөөрний эмчийн орон тоо, кабинет байхгүй тул тусlamж, үйлчилгээний хүртээмж хангалтгүй, өвчтөнд эмчилгээний дараах хяналт хийх боломжгүй байна.

Хүний нөөцийн хувьд 2012 оны байдлаар бөөрний мэргэжил эзэмшсэн 28 эмч ажилладгаас 21 нь Улаанбаатар хотод, 7 нь орон нутагт (Орхон, Сэлэнгэ,

⁹ Х.Гэлэгжамц, 1984 онд хийсэн судалгаа

¹⁰ T.Ariunaa Burden of CKD, proteinuria, and cardiovascular risk among Chinese, Mongolian, and Nepalese participants in the International Society of Nephrology screening programs.2010

¹¹ ЭХЭМҮТ-ийн статистик тоо баримт

Увс, Ховд, Дорнод, Хөвсгөл,Өвөрхангай аймагт), Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (ЭХЭМҮТ)-д улсын хэмжээнд нийт 7 хүүхдийн бөөрний эмч ажиллаж байна. Орон нутагт мэргэшсэн эмч бэлтгэгдээгүй байна.

Үнэлгээний дүнгээс¹² үзэхэд, бөөрний өвчин эмгэгийг хэвтэн эмчлүүлэхээр 8-14 хоног хүлээж байна. Хяналтанд тогтмол байвал зохих өвчтөн хяналтгүйгээс бөөрний архаг дутагдалд орох явдал их байна. Мөн бөөрний өвчин эмгэгийг оношлох лабораторийн болон дүрс оношилгооны багаж, оношлуур, тоног төхөөрөмжийн хүчин чадал, хүртээмж хангалтгүй, эдийн шинжилгээг хийж дүгнэлт гаргах эмгэг судлалын чадавхи бэхжээгүй¹³ зэрээс бөөрний өвчин эмгэгийг төгс оношилж, эмчилж чадахгүй байгаа нь өвчин даамжрах, бөөрний архаг дутагдлаар хүндрэх нөхцөл болж байна.

1.4 Тулгамдсан асуудал

1. Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, илрүүлэх, оношлох, эмчлэх, хянах удирдлага, зохион байгуулалт

- Бөөрний эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний талаарх бодлого, хууль, эрхзүйн баримт бичиг цөөн,
- Бөөр орлуулах, бөөр шилжүүлэн суулгах тусlamж, үйлчилгээг хөгжүүлэх орчин хангалтгүй,
- Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт бөөрний кабинетгүй,
- Бөөрний мэргэшсэн эмчийн тоо хангалтгүй,
- Бөөрний өвчин эмгэгтэй хүнийг хянах тогтолцоо байхгүй,
- Бөөрний өвчин эмгэгт хүргэж байгаа шалтгааныг тодорхойлсон судалгаагүй,
- Ажлын байрны орчин нөхцөл, хувцаслалт, хооллолт, улирлын онцлогтой холбоотой хөдөлмөрийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагаа сул.

2. Бөөрний өвчин эмгэгийн сэргийлэлт, эрт илрүүлэг, хяналт

- Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэх, хянах стандарт, удирдамж, гарын авлага, материал хангалтгүй,
- Эрт илрүүлэх шинжилгээ, үзлэгийг зохион байгуулж, дүгнэх, эрүүлжүүлэх, хянах тогтолцоо бүрдээгүй,
- Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэх, хянах, зөвөлгөө өгөх талаар эмч, мэргэжилтний мэдлэг, дадал хангалтгүй,
- Бөөрний өвчин эмгэгээс эрт илрүүлэх багаж, оношлуурын хангамж, хүчин чадал дутагдалтай,
- Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэх, хянах санхүүжилтгүй,
- Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэх талаар олон нийтийн мэдлэг, хандлага, дадал муу, салбар хоорондын хамтын ажиллагаа сул.

¹² Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хийсэн үнэлгээ, 2013, ЭМШУИС

¹³ Эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хийсэн үнэлгээ, 2013, ЭМШУИС

30

Хүснэгт 1. Бөөрний өвчин эмгэгээс эрт илрүүлэх чадамжийн байдал

Зонхилох өвчнүүд	Эрт илрүүлэлт	Сум, өрхийн ЭМТ	НЭ	Төв, тусгай мэргэжлийн төв, БОЭТ
Түүдгэнцрийн эмгэг N00-08	Цусанд креатинин тодорхойлох	-	+	+
	Шээсний ерөнхий шинжилгээ	+	+	+
	Шээсний тунадасын шинжилгээ	-	+	+
	Шээсэнд креатинин тодорхойлох	-	-	-
	Шээсэнд микроальбумин тодорхойлох	-	-	+/-
Бөөрний сувганцрын эмгэгүүд N10-16	Бөөрний эдийн шинжилгээ	-	-	-
	Цусанд креатинин тодорхойлох	-	+	+
	Шээсний ерөнхий шинжилгээ	+	+	+
	Хэвлэйн хэт авиан шинжилгээ	+/-	+	+
Бөөрний үйл ажиллагааны дутагдал N17-19	Цусанд креатинин тодорхойлох	-	+	+
	Шээсний ерөнхий шинжилгээ	+	+	+
	Шээсний тунадасын шинжилгээ	-	+	+
	Шээсэнд креатинин тодорхойлох	-	-	-
	Шээсэнд микроальбумин тодорхойлох	-	-	+/-
	Хэвлэйн хэт авиан шинжилгээ	+/-	+	+
Бөөрний чулуу N20-23	Цусанд креатинин тодорхойлох	-	+	+
	Шээсний ерөнхий шинжилгээ	+	+	+
	Шээсний тунадасын шинжилгээ	-	+	+
	Шээсэнд кальци, магни, оксалат, цитрат тодорхойлох	-	-	-
	Хэвлэйн хэт авиан шинжилгээ	+/-	+	+

+ боломжтой

- боломжгүй

+ - боломжтой боловч хийгдэхгүй байгаа

3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

- Бөөрний өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийн нэвтрэлт, хэрэгжилт хангалтгүй,
- Бөөрний өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээний талаар мөрдөгдөж байгаа стандарт, удирдамж цөөн, хэрэгжилт нь хангалтгүй,
- Эрүүл мэндийн анхан болон үндсэн мэргэжлийн тусламжид үзүүлж буй бөөрний тусламж, үйлчилгээ хангалтгүй,
- Үндсэн мэргэжлийн тусламж үзүүлж буй байгууллагуудад шээсэнд креатинин, микроальбумин, эрдэс бодис, сийвэнд эрдэс бодис тодорхойлох тоног төхөөрөмж, урвалж байхгүй,
- Хүүхэд, эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын бөөрний өвчин эмгэгийн үед тусламж, үйлчилгээ үзүүлэх мэдлэг, дадал дутмаг,
- Бөөр орлуулах, бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй (одоогоор 58 гемодиализийн аппарат байгаа нь одоо байгаа 400 гаруй бөөрний архаг дутагдалтай өвчтөнд хүрдэггүй),
- Бөөрний өвчин эмгэгийн эмчилгээнд зайлшгүй шаардлагатай орчин үеийн эм, эмийн бэлдмэлийн олдоц, хэрэглээ муу,
- Эдийн тохироо үгүй тохиолдолд бөөр шилжүүлэн суулгах орчин бүрдээгүй,
- Бөөрний түүдгэнцрийн эмгэгийн оношилгоо, эмчилгээнд бөөрний эдийн шинжилгээг хэрэглэж хэвшээгүй,
- Бөөрний өвчин эмгэгийн тусламж, үйлчилгээнд рашаан сувиллын тусламж, үйлчилгээг стандартын дагуу хэрэглэдэггүй,

Хүснэгт 2. УНТЭ-ийн диализ эмчилгээний зардал (Сүүлийн 3 жилээр)

№	Тайлант он	Нийт төсөв	Нийт эмийн төсөв	Диализ эмчилгээний зарцуулалт	Нийт төсөвт эзлэх хувь /диализ/	Нийт эмийн төсөвт эзлэх хувь /диализ/
1	2010	8,069,312,900	3,864,075,200	1,184,519,497	14.68	30.65
2	2011	10,264,704,400	4,953,835,200	1,767,850,504	17.22	35.69
3	2012	14,565,203,900	6,278,501,600	1,787,065,615	12.27	28.46

2010-2012 онуудад УНТЭ-ийн нийт төсвийн 15 хувь, эмийн төсвийн 32 хувийг тус тус эзэлж байна.

Бөөр шилжүүлэн суулгах эмчилгээг 2006 оноос эхлүүлэн, өнөөдөр Монголд 69 гаруй өвчтөнд бөөр шилжүүлэн суулгасан бөгөөд мэс засал эмчилгээний үнэ 11 сая, үүний 8,5 сая төгрөгийг улсын төсвөөс зарцуулж байгаа ба дархлаа дарангуйлах эм нэг хүнд 1 жилд 1 сая гаруй төгрөгийн өртөгтэй байна.

4. Бөөрний өвчин эмгэгийн бүртгэл, мэдээлэл, хяналт, тандалт

- Мэдээ цуглуулахад ашиглаж буй бүртгэлийн маягт, анхан шатны баримтын хөтлөлт хангалтгүй, чанарын хяналт сул,

- Мэдээ, мэдээллийн чанар, түүнийг түгээх, дамжуулах болон бүх шатны түвшинд (ялангуяа бодлого гаргах түвшинд) хэрэглэх хэрэглээ хангалтгүй,
- Бөөрний өвчин эмгэгийн үндэсний түвшний тархварзуйн судалгаагүй,
- Сум, аймаг, улсын түвшинд хянагдах бөөрний өвчиний хяналтын чанар хангалтгүй,
- Өвчиний олон улсын ангиллаар бөөрний өвчиний бүртгэл хангалтгүй,
- Бөөрний архаг өвчин эмгэгийн тохиолдол, нас барагт, эрсдэлт хүчин зүйлсийн мэдээллийн сангуй,
- Бөөр хамгаалах, орлуулах, шилжүүлэн суулгах эмчилгээний нэгдсэн бүртгэл хяналтын тогтолцоо бүрдээгүй,
- Бөөрний өвчин эмгэгийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн эдийн засаг, эрүүл мэндийн үр ашгийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил байхгүй.

Иймд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, тандан судлах, хянах асуудлыг цогцоор нь шийдвэрлэх урт хугацааны, үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага байгаа тул “Бөөр хамгаалах” үндэсний стратегийг боловсрууллаа.

Хоёр. Стратегийн зорилго

Бөөрний өвчин эмгэг, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, хянах, тандах тогтолцоог бүрдүүлэн, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах замаар бөөрний өвчин эмгэгийн тархалтыг тогтоон барих, улмаар бууруулахад энэхүү стратегийн зорилго оршино.

Гурав. Стратегийн зорилт, үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

Стратегийн зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

3.1. Зорилт 1. Бөөрний тусlamж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн орчныг бүрдүүлэх

Хүрэх үр дүн:

Бөөрний өвчин эмгэгийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн орчин бүрдэж, тусlamж үйлчилгээний чанар, хүртээмж, тогтвортой байдал сайжирна.

Үйл ажиллагааны чиглэл:

- 3.1.1 Бөөр хамгаалах үндэсний стратегийг хэрэгжүүлэх, удирдан зохицуулах тогтвортой механизмыг бий болгох;
- 3.1.2 Бөөрний өвчин эмгэгт хүргэдэг эрсдэлт хүчин зүйлсийг хүн амын дунд бууруулах зорилгоор “Халдварт бус өвчинөөс сэргийлэх, хянах”, “Амны хөндийн эрүүл мэнд”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Зөв хооллох, дасгал хөдөлгөөнийг дэмжих” зэрэг үндэсний болон олон улсын хөтөлбөр,

стратегийн үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх;

- 3.1.3 Бөөрний өвчин эмгэгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх хууль, эрхзүйн орчныг сайжруулах;
- 3.1.4 Бөөрний өвчин эмгэгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний өртөг, зардлыг тооцон, санхүүжилтийн оновчтой механизмыг бүрдүүлэх;
- 3.1.5 Хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээний онцлог, хүртээмж, өвчлөлийн байдалд үндэслэн хүний нөөцийг бэлтгэх, бүтэц, орон тоог зохицуулах, байршуулах цогц арга хэмжээ авах;
- 3.1.6 Эрүүл мэндийн байгууллагуудын бөөрний өвчин эмгэгийн тусламж, үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлэх;
- 3.1.7 Үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд төрийн захиргаа, төрийн үйлчилгээний болон төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, олон нийтийн хамтын ажиллагааг дэмжих, татан оролцуулах эрхзүйн орчинг бүрдүүлэх.

3.2 Зорилт 2. Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэх, хянах тогтолцоог бүрдүүлэх

Хүрэх үр дүн:

Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэх, хянах тогтолцоог нэвтрүүлснээр бөөрний өвчин, эмгэгийн тархалт буурна.

Үйл ажиллагааны чиглэл:

- 3.2.1 Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүлжүүлэх олон улсын шилдэг туршлагыг судлан нэвтрүүлэх;
- 3.2.2 Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүлжүүлэх стандарт, удирдамж, эмнэлзүйн хөтчийг боловсруулж, мөрдүүлэх;
- 3.2.3 Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, илрүүлэх үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлэх, оновчтой болгох;
- 3.2.4 Хүн амын бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтмолжуулах хэвлэл мэдээллийн байгууллага, бусад салбар, олон нийтийг татан оролцуулах;
- 3.2.5 Артерийн гипертензи, чихрийн шижинтэй, удамд нь бөөрний өвчнөөр өвчилж байсан хүмүүст чиглэсэн эрсдэлт зан үйлийг өөрчлөх, зан үйлийн мэдээлэл харилцааны ажлыг бусад хөтөлбөр, төслийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулах;
- 3.2.6 Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, эрүүл мэндээ хянаж сайжруулах талаар сургуулийн өмнөх боловсрол, ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөр, багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын агуулга, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх;
- 3.2.7 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бөөрний өвчнийг эрт илрүүлэх лабораторийн шинжилгээ хийх чадавхи бий болгох;
- 3.2.8 Бүх төрлийн урьдчилан сэргийлэх болон хянах үзлэгт шээсний болон бөөрний үйл ажиллагаа тодорхойлох шинжилгээ хийх нөхцөл бүрдүүлж,

бөөрний өвчин эмгэгийг илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулж, эрүүлжүүлэх, үр дүнг тооцох механизмыг бүрдүүлэх;

- 3.2.9 Анхан шатны эрүүл мэндийн байгууллага, цэцэрлэг, сургууль, цэрэг, уул уурхайн эмчээр дамжуулан шээсний түргэвчилсэн оношлуураар эрт илрүүлэх оношлох, эмчлэх, хянах тогтолцоог бүрдүүлэх;
- 3.2.10 Зорилтот болон эрсдэлт бүлгийн хүн амын онцлог, эрэлт хэрэгцээнд тулгуурлан өрх, сумын эмч, эмнэлгийн мэргэжилтний бөөрний өвчин, эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэх, хянах мэдлэг, үр чадварыг дээшлүүлэх;
- 3.2.11 Бөөрний өвчин эмгэгийг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, зөвлөгөө өгөх, хянах чиглэлд алсын зайн анагаахыг тулхүү ашиглах, өргөжүүлэх.

3.3 Зорилт 3. Бөөрний өвчин эмгэгийн үед үзүүлэх эмнэлгийн тусlamж, үйлчилгээг олон улсын жишигт хүргэх

Хүрэх үр дүн:

Бөөрний өвчин эмгэгийн үед үзүүлэх эмнэлгийн тусlamж, үйлчилгээг олон улсын жишигт хүргэснээр бөөрний архаг өвчний тархалт, хүндрэл буурах нөхцөл бүрдэж, нийгэм, эдийн засгийн дарамтыг багасгана.

Үйл ажиллагааны чиглэл:

- 3.3.1 Бөөрний өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээний шинэ дэвшилтэт арга технологийг судлан нэвтрүүлэх;
- 3.3.2 Бөөрний өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээний талаар мөрдөгдөж байгаа стандарт, удирдамжийг хянаж шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэх, энэ чиглэлээр эрүүл мэндийн бүх шатлалын түвшинд үндэсний чадамж бүрдүүлэх;
- 3.3.3 Бөөрний өвчин эмгэгтэй, бөөрний архаг дутагдалтай өвчтөний эмчилгээнд олон улсын стандартанд нийцсэн, эмнэлзүйн үр ашигтай, баталгаатай эмийг нэвтрүүлэх талаар судлан, холбогдох арга хэмжээг авах;
- 3.3.4 Эрүүл мэндийн анхан болон үндсэн мэргэжлийн тусlamжид үзүүлж буй бөөрний тусlamж, үйлчилгээний байдалд үнэлгээ хийж хүртээмж, чанарыг сайжруулах арга хэмжээ авах;
- 3.3.5 Бөөр орлуулах эмчилгээний тусlamж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх чадавхийг бэхжүүлэх;
- 3.3.6 Бөөр шилжүүлэн суулгах мэс заслын тусlamж, үйлчилгээтэй холбогдох хууль эрхзүйн орчинг бүрдүүлэх замаар хөгжүүлэх;
- 3.3.7 Бөөрний өвчний тусlamж, үйлчилгээнд эмийн эмчилгээний үр дүнг дэмжих, дахилтаас сэргийлэх зорилгоор сувиллын тусlamж, үйлчилгээг хөгжүүлэх.

3.4 Зорилт 4. Бөөрний өвчин эмгэгийн бүртгэл мэдээлэл, хяналт, тандалтын тогтолцоог хөгжүүлэх

Хүрэх үр дүн:

Бөөрний өвчин эмгэг, нас барагт, эрсдэлт хүчин зүйлсийн хяналт, бүртгэл, тандалт боловсронгуй болж, нотолгоонд сууринсан тусlamж, үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

- 3.4.1 Бөөрний өвчин эмгэгийн диспансерийн хяналтын өнөөгийн байдалд үнэлгээ өгч, өвчтөний хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- 3.4.2 Бөөрний өвчин эмгэгийн бүртгэлийг өвчний олон улсын ангиллын дагуу бүртгэх ажлыг сайжруулах;
- 3.4.3 Бөөрний өвчин эмгэгт нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг тогтоох болон бөөрний өвчлөл, нас баралтын тархварзүйн судалгаа хийн, мэдээллийн санг бүрдүүлэх;
- 3.4.4 Бөөр хамгаалах, орлуулах, шилжүүлэн суулгах эмчилгээний нэгдсэн бүртгэл хяналтын тогтолцоог бий болгох;
- 3.4.5 Хоёрдогч урьдчилан сэргийлэлт, диспансерийн хяналт, хүүхэд нааснаас насанд хүрэгчдийн эмнэлэгт шилжүүлэх тогтолцоог бүрдүүлэх;
- 3.4.6 Бөөрний өвчин эмгэгийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны эдийн засгийн болон эрүүл мэндийн үр ашгийн талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхэд дэмжлэг үзүүлэх;

Дөрөв. Стратегийг хэрэгжүүлэх зарчим, удирдлага, зохион байгуулалт

4.1 Стратегийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

- 4.1.1 Иргэд, хамт олны дунд эрүүл аж төрөх зан үйл төлөвшихдэд дэмжлэг үзүүлэхүйц “эрүүл мэндийг дэмжигч” орчин бүрдүүлэх, бөөрний өвчин, эмгэгийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн салбар дундын хамтын ажиллагаанд тулгуурлана;
- 4.1.2 Бөөрний өвчин, эмгэгийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах талаар бодлого боловсруулж чадавхи бүрдүүлэх, түншлэх, мэдээллээр хангах болон хэрэгжүүлэх бүх түвшинд иж бүрнээр хандана;
- 4.1.3 Иргэд, гэр бүл, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийгмийн оролцоог хангана;
- 4.1.4 Нийт хүн ам, өвчлөх эрсдэлтэй бүлэг болон өвчилсөн хувь хүн аль алинд нь чиглэсэн иж бүрэн хандлага, баримт нотолгоонд түшиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;
- 4.1.5 Одоогийн байгаа дэд бүтэц болон нөөцэд тулгуурлан эрүүл мэндийг дэмжих, өвчлөхөөс урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагаа, шатлал хоорондын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангана;
- 4.1.6 Эрүүл мэндийн бусад хөтөлбөр, төслийн үйл ажиллагаатай уялдуулах замаар санхүүжилтийг үр ашигтай нэмэгдүүлнэ.

4.2 Стратегийн удирдлага, зохион байгуулалт

ХБӨ-нөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрт зонхилон тохиолдох халдварт бус өвчний нийтлэг эрсдэлт хүчин зүйлс, тэдгээрээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих болон эдгээр зонхилон тохиолдох ХБӨ-нийг эрт илрүүлэх, хянах нийтлэг асуудлыг тусгасан бөгөөд бөөр хамгаалах үндэсний стратеги нь бөөрний

өвчин эмгэг, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсээс урьчилсан сэргийлэх, эрт илрүүлэх, хянахад чиглэсэн өвөрмөц стратеги, үйл ажиллагааг тусгасан болно.

Стратегийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, оролцогч байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс, Эмнэлгийн тусламжийн хэлтэс гүйцэтгэнэ.

Стратегийг хэрэгжүүлэхэд Боловсрол, шинжлэх ухааны яам, Батлан хамгаалах яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, ЭМЯ-ны харьяа Эрүүл мэндийн байгууллага бусад төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын түншүүдтэй хамтран ажиллана.

Тав. Стратеги хэрэгжүүлэх хугацаа, үе шат, санхүүжилт

5.1. Стратегийг 2013-2018 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

5.1.1. Нэгдүгээр үе шат 2013-2016 он;

5.1.2. Хоёрдугаар үе шат 2016-2018 он.

5.2. Стратеги хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.2.1 улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

5.2.2 Засгийн газрын зарим тусгай сан (Шинжлэх ухаан технологийн сан, Эрүүл мэндийг дэмжих сан)-гийн хөрөнгө;

5.2.3 гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, Иргэдийн хандив, тусламж;

5.2.4 олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;

5.2.5 хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Стратегийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлт

6.1 Үндэсний хэмжээнд стратегийн хэрэгжилтэд дунд хугацааны болон төсгөлийн үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу хийнэ. Үнэлгээг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

6.3. Стратегийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

№	Шалгуур үзүүлэлт	Эх үүсвэр	Суурь үзүүлэлт 2013 он	2016 онд	2018 онд
1	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг 10000 хүн амд	ЭМСҮ	764.1	754.0	750.0
2	Суваг-завсар эдийн архаг бөөртөс (N11) өвчлөл 10000 хүн амд	ЭМСҮ	236.5	230.5	225.5
3	Гломерулопати оношлогдсоноос хойш 7-оос дээш жилийн дараа бөөрний архаг дутагдалд орсон хүмүүсийн эзлэх хувь	Судалгаа	-		

37

			ЭМСҮ	50%	75%	90%
4	Диализ эмчилгээнд хамрагдалтын хувь					
5	Бөөрний өвчний эрт илрүүлэгт хамрагдсан сургууль, цэцэрлэгийн насны хүүхдийн хувь	БШУЯ-ны тайлан	-		80%	100%
6	Бөөрний өвчний эрт илрүүлэгт хамрагдсан сургууль, цэцэрлэгийн насны хүүхдээс өвчин эмгэг илэрсэн хувь	БШУЯ-ны тайлан	-		80%	100%
7	Давсны хэрэглээ (гр /өдөр)	ХБӨОГ-ийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа, 2009		9.6	9.1	8.6
8	Хоногт 2 литрээс доошгүй ус уудаг хүмүүсийн хувь	Судалгаа	-			
9	Хүнсний ногоог өдөрт 2-оос дээш нэгж хэрэглэж байгаа хүний тоо (хувиар)	ХБӨОГ-ийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа, 2009		49.4	55.0	60.6
10	Хоёрдугаар шатлал дахь бөөрний кабинетын тоо	ЭМСҮ	-	29	29	
11	Эдийн шинжилгээгээр онош баталгаажсан бөөрний өвчин эмгэгтэй хүний хувь	ЭСҮТ-ийн статистик мэдээ	-		50%	100%
12	Монгол улсад бөөр шилжүүлэн суулгах эмчилгээнд хамрагдсанас хойш 5 ба түүнээс дээш жил амьдарсан хүний хувь	ЭМСҮ	-			
13	Бэлтгэгдсэн эмчийн тоо	ЭМСҮ	-		29	58
14	Батлагдсан стандарт, удирдамжийн тоо	ЭМЯ, СХЗГ	7	12	17	

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
тусалын хөөрдугаар хавсралт

**БӨӨР ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа		Хариуцах байгууллага/ газар/хэлтэс	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа	Шалгуур үзүүлэлт
1. Бөөрний өвчин эмгэгийн эрүүл мэндийн тусламж, Үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, эрхэйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:					
1	Бөөрний өвчин эмгэгийн эрүүл мэндийн тусламж, Үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, эрхэйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:	ЭМЯ, УНТЭ Холбогдох байгууллагууд	ЭМШУИС, ЭМХТ Холбогдох байгууллагууд	2014	Үнэлгээний зөвлөмж тайлан, хэмжээ
2	Бөөрний өвчин эмгэгийн эрүүл мэндийн тусламж, Үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, эрхэйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд:	ЭМЯ Илрүүлэх, эрүүлжүүлэх, хянах өртгийг эрүүл мэндийн даатгалын сан болон эрүүл мэндийг дэмжих сангийн эх үүсвэрээс санхүүжүүлэх механизмыг судлах, хэрэгжүүлэх	СЯ, НХЯ, ОУБ НДЕГ	2014-2015	Гарсан шийдвэр, авсан арга хэмжээ
3	Өртөг өндөртэй болон удаан хугацаанд нөхөн эмчилгээ шаардлагатай бөөрний зарим эмгэгийн эмчилгээг НЭМД-аас санхүүжүүлэх асуудлыг судлаж, шийдвэрлэх	ЭМЯ НХЯ НДЕГ	НХЯ НДЕГ	2014-2015	Гарсан шийдвэр, авсан арга хэмжээ
4	Олон улсын болон Үндэсний түвшиний уулзалтыг тодорхой сэдвүүдээр зохион байгуулах	ЭМЯ, ДЭМБ Хөтөлбөрийн баг	УНТЭ, ОУБ, ТББ, НИЙГЭЛЭГ, холбоод, аж ахуйн нэгж	2014	Уулзалтын удирдамж, хөтөлбөр, оропцочдын тайлан
5	Бөөрний, бөөрний мэс заслын, хүүхдийн мэргэжлийн эмчийг бэлтгэх, гадаад, дотоодод урт, богино хугацааны сургалтандаа хамруулах	ЭМЯ ЭМХТ, ЭМШУИС Улсын төв болон тусгай мэргэжлийн төв	Жил бүр Сургалтанд хамрагдсан, бэлтгэгдсэн тоо		Сургалтын хөтөлбөр,

6	Дипломын өмнөх, төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт бөөр судалын чиглэлээр тусгах (ОУ-ын загвараар дотрын резидент 2-оос дээш жил, бөөрний мэргэжлийг 1-ээс дээш жилээр бэлтгэх)	БШУЯ	ЭМЯ, ЭМШУИС, мэргэжлийн нийгэмпэг, холбоод	ЭМХТ, ТББ, оноос	2014	төлөвлөгөө
7	Бөөр орлуулах эмчилгээний багийн бүрэлдэхүүн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, судасны мэс засалч, дурс оношилгооны эмч, сувилгач, техникчийг ботино хугацаагаар гадаад, дотоодод Мэргэшүүлэх боловсруулан бэлтгэх	ЭМЯ, ЭМХТ	БШУЯ, ЭМШУИС	2014-2018	Батлагдсан төлөвлөгөө, бэлтгэгдсэн мэргэшүүлэх тоо	БШУ, Эрүүл мэндийн сайжин тушаал болон эмчийн
8	Хүн амын дунд бөөрний өвчин, эмгэгийн тархалтын байдал, хэтийн төлөв, эрэлт хэрэгцээг судлан тогтоосны үндсэн дээр хүн амд ноогдох бөөрний эмчийг мэргэшүүлэх, байршуулах	ЭМЯ	БШУЯ, ЭМШУИС	2013-2014	Бэлтгэгдсэн мэргэшүүлэх тоо	Бэлтгэгдсэн болон эмчийн
9	Хүн амын дунд бөөрний өвчиний тархалтын байдал, хэтийн төлөв, эрэлт хэрэгцээг судлан тогтоосны үндсэн дээр багаж, оношилuur, тоног төхөөрөмжийг төлөвлөх, хангах	ЭМЯ	СЯ, ОУБ	2013-2016	Хангадсан тоног төхөөрөмжийн тоо	Хангадсан тоног
10	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт бөөрний кабинет ажиллуулах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх;	ЭМЯ, Аймаг, ОУБ	Нийислэлийн ЭМГ, НЭ	2013 - 2014	-	Бөөрний кабинеттai НЭ-ийн тоо
11	Бөөрний тусламж үйлчилгээний тогтвортой байдлыг хангах зорилгоор судалгаа, шинжилгээний үйл ажиллагаанд дэмжлэг узүүлэн, хамтран ажиллах	ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл	Холбогдох байгууллага, ОУБ, ТББ, Залуу бөөр судлаачдын клуб	2014-2016	Хамтран ажилласан тайлан	Хамтран ажилласан
12	Төрийн бус байгууллагын түншлэлийг хөгжүүлэх арга хэмжээ авах	ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл	Холбогдох байгууллагууд, ОУБ	2014-2016	Хамтран төлөвлөгөө, тайлан	Хамтран ажилласан
13	Бөөрний архаг өвчин эмгэгийн хөдөлмөрийн чадвар алдаалтын бодлогын баримт бичиг, эрх зүйг сайжруулах, нэмэлт оруулах	Нийгмийн хамгааллын яам	ЭМЯ, Мэргэжлийн салбар зөвлөл	2014	ХЧА тогтоох журамд оруулсан санал	ХЧА тогтоох журамд

14	Үндэсний тувшинд үйл ажиллагаа явуулах чадавхитай бөөрний нэгдсэн нийгэмлэг холбоодын эрх зүйн орчныг бурдүүлэх	ЭМЯ Мэргэжлийн са, бар зөвлөл	Холбогдох байгууллага, ОУБ, ТББ	2014- шийдвэр, авсан арга хэмжээ	Гарсан тушаал,
15	Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд тусгай төлөвлөгөөний дагуу жил бүр 3-4 аймаг, дүүрэг, эрүүл мэндийн байгууллагад явж хяналт-шинжилгээ хийх	ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл	Холбогдох байгууллагууд, ОУБ, ТББ	Хөтөлбө рийн хугацаа нд	Хяналт, үнэлгээний тайлан
2. Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэх, хянах тогтолцоог бурдүүлэх зорилтын хүрээнд:					
1	Бөөрний өвчин эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэх стандарт, удирдамж, эмнэлгийн хөтчийг боловсруулж баттуулж, хэрэглэх	ЭМЯ сэргийлэх, эрт иilрүүлэх хөтчийг боловсруулж баттуулж, хэрэглэх	ЭМШУИС ОУБ, Мэргэжлийн салбар зөвлөл	2013- 2014 тоо	Батлагдсан Стандарт, удирдамж, эмнэлгэйн хөтөчийн тоо
2	Бөөрний өвчин эмгэгэйн эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, эрт илрүүлэх үйл ажиллагааны арга зүйн чиглэлээр боловсон хүчинийг гадаад, дотоодод сургах, мэргэжлийг нь дээшгүүлэх	ЭМЯ эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, эрт илрүүлэх үйл ажиллагааны арга зүйн чиглэлээр боловсон хүчинийг гадаад, дотоодод сургах, мэргэжлийг нь дээшгүүлэх	ЭМШУИС, НЭМҮТ, ОУБ, Мэргэжлийн салбар зөвлөл	Хөтөлбө рийн хугацаа нд	Сургалтад хамрагдсан боловсон хүчиний тоо, хөтөлбөр тоо
3	Бүх шатлалд бөөрний өвчин эмгэгийг эрт илрүүлэх энгийн, үр дүн сайтай багаж, урвалж, түргэвчилсэн оношлуураар хангах	ЭМЯ шатлалд бөөрний өвчин эмгэгийг эрт иilрүүлэх энгийн, үр дүн сайтай багаж, урвалж, түргэвчилсэн оношлуураар хангах	Мэргэжлийн зөвлөл, ОУБ	2014 оноос	Хангагдсан урвалж, түргэвчилсэн оношлуурын тоо, терөл
4	Бөөрний өвчин эмгэгт өртөх ондэр эрсдэлтэй булэг хүн амд чиглэсэн үрьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг тодорхой давтамжтайгаар зохион байгуулж эмчлэх, хянах, үр дүнг тооцох механизмыг бурдүүлэх	ЭМЯ бүрдчилсан үр дүнг тооцох механизмыг бурдүүлэх	НЭМҮТ, Холбогдох байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа	2014 оноос	Авсан хэмжээний удирдамж
5	Сургууль, цэцэрлэгийн багш бэлтэх сургуулийн сургалтын хөтөлбөрт хүүхдийн сэргийлэх бөөрний эмгэгээс үрьдчилсан талаар тусгаж хэрэгжүүлэх	БШУЯ ЭМЯ, НЭМҮТ		2014- 2018	Сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгадсэн санал
6	Бөөрний өвчиний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр амжилттай ажиллаж үр дүнд хурсэн хамт олныг нийтэд мэдээлэн	ЭМЯ Олон нийтийн байгууллага	НЭМҮТ, Холбогдох яам, байгууллага ТББ	2014 оноос	Шалгур боловсруулж байгууллагыг узыулэлт

	урамшуулах сурталчлах, бүрдүүлэх	урамшуулах механизмыг			
7	Шээсний түргэвчилсэн оншлуураар сургууль, цэцэрлэгийн эмч нарыг хангах, тэднийг сургалтад хамруулах	БШУЯ	ЭМЯ, НЭМҮТ Холбогдох байгууллага ТББ, ЭМХТ	яам, оноос	2014 Ханыгдсан - сургууль, цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр, тайлан
8	Бөөрний өвчин эмгэгийг түргэвчилсэн оношлуураар эрт илрүүлэх узлэгийг сургуулийн өмнөх насны хүүхдэд жилд 1 удаа, сургуулийн насны хүүхдэд жилд 2 удаа тогтолцоулж, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээ авах	БШУЯ, орон нутгийн Засаг захиргаа, ЭМГ	Аймаг, дүүргийн эмнэлэг, ТББ	жил, хагас жил бүр	ШЕШ-Д хамрагдсан хувь, Эрүүлжүүлж, урьдчилсан сэргийлэх үйл ажиллагааны удирдамж, тайлан
9	Ажлын байрны стандарт, зарим хүнд яам нөхцөлтэй ажлын байранд беөр хамгаалах орчин бүрдүүлэх, хувцаслалтын тухай асуудлыг тусгах	Хөдөлмөрийн яам	ЭМЯ, НЭМҮТ, ТББ, ОУБ	оноос	Тусгасан шийдвэр тушаал,
10	Хоёрдогч урьдчилан сэргийлэлт, диспансерийн хяналт, хүүхэд наснаас насанд хүрэгсдийн эмнэлэгт шилжүүлэх аргачилсан зөвлөмж, боловсруулах	ЭМЯ	НЭМҮТ, мэргэжлийн нийгэмлэг, холбоод	2014	Аргачилсан зөвлөмж
11	"Бөөр хамгаалах дэлхийн өдрийг тэмдэглэх" жил бүр тодорхой сэдвээр тэмдэглэх	ЭМЯ	НЭМҮТ, ЭМШУИС Аймаг, нийслэлийн ЭМГ, ХМБ	ОУБ, Жил бүр	Үйл тайлан ажиллагааны
12	Өсвөр насны хүүхэд, цусны даралт ихсэлт, чихрийн шижинтэй, удамд нь беөрний өвчнөөр өвчилж байсан хумуус, нөхөн уржихуйн насны болон жирэмсэн эмэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл зан үйл төлөвшүүлэх, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	ЭМЯ	НЭМҮТ, Хэнахүү хөтөлбөрийн ба ХБӨ-тэй хөтөлбөрийн ба	Жил бүр	Зорилтот бүлэгт чиглэн үйл ажиллагаа зохион байгуулсан тайлан
13	Халдварт бус өвчиний эрсдэлт хүчин зүйлсийг иргэд өөрсдөө хянах дадал хэвшилтэй болгох, энэ ажилд гэр бүлийн гишүүдийн оролцоог	ЭМЯ	НЭМҮТ, ОУБ, ТББ, НИЙГЭМЛЭГ, холбоод, Хэвлэл Мэдээллийн	Жил бүр	MCC-ны тоо, төрөл, тайлан

14	Сургууль, сургалт, сурталчилгааны материал, аргачлаал боловсруулах, сургалт, сурталчилгаа явуулах агуулгад хувийн эрүүл мэнд хичээлийн ариун цэврийн дадал хэвшилтэй болгох талаар тусгах, хэрэгжүүлэх	БШУЯ ЭМЯ	Мэргэжлийн салбар зөвлөл, НЭМҮТ, Боловсролын газар, ХМБ	2014 оны эхний улиралд
15	Сургууль, цэцэрлэгийн эмчийн ажлын байрны тодорхойлолтод хуухдийн нас, биений онцлогт тохирсон беөр хамгаалах зан уйл төлөвшүүлэх ажлыг тусгах, үнд чиглэсэн сургалтын материал, кино, узүүлэн боловсрнуулж, түгээх	БШУЯ	ЭМЯ, НЭМҮТ, ОУБ,	2014 оны эхний улирлаас с
16	Бөөрний өвчин эмгэгийг эрт илрүүлэх, зөвлөгөө өгөх, хянах чиглэлээр мэргэжилтэнд зориулсан гарын авлагын материал боловсруулах, сургалт зохион байгуулах (алсын зайн, ажлын байран дээр, бусчилсэн байдлаар)	ЭМЯ	ОУБ, ЭМШУИС, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоод	2014 оноос эхлэн
17	Бөөрний өвчин эмгэгийг сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажилд салбар хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгуулан, хэрэгжүүлэх	ЭМЯ	НЭМҮТ, БШУЯ, ХЯ, ХХҮЯ болон бусад холбогдох салбарууд	Хөтөлбөрийн хугацааныд
18	Монгол орны цаг уур, улирлын онцлог, зан үйпийг бууруулах талаар олон нийтэд чиглэсэн компанийт ажлыг тогтол зохион байгуулах	ЭМЯ	НЭМҮТ, Хөдөлмөрийн яам, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, ХМБ	Жил бүр
19	Жирэмсний хяналтын шинжилгээний багцад шинжилгээг эрдэлт шинжилгээг тодорхойлох эрүүлжүүлэх арга хэмжээ авах	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, ЭМБ	2013-2014
20	Эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, эрүүл аж төрөх талаар олон нийтийн зүгээс гарсан	ЭМЯ	НЭМҮТ, ЭМШУИС	Тушаал, шийдвэр, хэрэгжилтийн тайлан
				Тушаал, Дэмжлэг Узүүлсэн шийдвэр,

74

	санаачилга, үйл ажиллагаа, жижиг төсөл, итэлбэр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх		Мэргэжлийн нийгэмлэг, холбоод	Гарсан шийдвэр, удирдамж, тайлан
21	Бөөний өвчин эмгэгийг эрт илрүүлэх үзлэгийг жил бүр улсын хэмжээнд зохион байгуулж шаардлагатай арга хэмжээ авч байх	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, ЭМБ	Жил бүр Гарсан шийдвэр, удирдамж, тайлан
22	Улс, хувийн байгууллагад ажиллагчдын үрьдчилан сэргийлэх Узлэгийн багцанд шээсний шинжилгээг оруулж, үр дунд үндэслэн эруулжүүлэх, үрьдчилан сэргийлэх арга хэмжээг авах тогтолцоог бурдуулэн хэрэгжүүлэх	ЭМЯ Аймаг, НИЙСЛЭЛИЙН ЗДТГ, ЭМГ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яам, ҮЭХ	Гарсан шийдвэр, удирдамж, тайлан
23	Цэрэг татлагын үеийн үрьдчилан сэргийлэх үзлэгийн багцад шээсний ерөнхий шинжилгээг тусган, илрүүлэх, эруулжүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулан хэвшүүлэх	Батлан хамгаалах яам, ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ, ЭМБ	Хамрагдалтын хувь Эрүүлжилтийн хувь 2014 оноос
3. Бөөний өвчин эмгэгийн үед үзүүлэх эмнэлгийн тусlamаж, үйлчилгээг олон улсын жишигт хүргэх зорилтын хүрээнд:				
1	Оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж, алгоритмыг олон улсын стандарт, удирдамжтай уялдуулан боловсруулах, баттуулах, хэрэгжилтийг хангах	ЭМЯ, Клиникийн эмнэлгүүд	ОУБ ЭМШУИС ЭХЭМҮТ	Жил бүр Шинээр боловсрууласан стандартын тоо Хэрэгжилтийн тайлан
2	Бөөний өвчиний талаар мөрдөгдөж байгаа стандарт, удирдамжийг тусламж үйлчилгээнд хэрэглэх хэвшүүлэх ажлыг цогцоор хийх зөвлөл	ЭМЯ, Мэргэжлийн салбар зөвлөл	УНТЭ, мэргэжлийн төв ЭМШУИС, ТББ, мэргэжлийн нийгэмлэг, холбоод	2013-2016 тусгай Батлагдсан төлөвлөгөө ажлын тайлан
3	Бөөний өвчин эмгэгийн оношилгоонд багаж, тохог төхөөрөмжөөр хангах, сургалт зохион байгуулах, стандарт мөрдүүлэх/	ЭМЯ	ОУБ ЭМШУИС Улсын төв болон тусгай мэргэжлийн төв, ЭСҮТ	2014 оноос Тоног нийлүүлсэн байдал Хийгдсэн биопсийн тоо
4	Бөөний төрөлжсөн, тусгай тусламж, үйлчилгээний чиглэлээр үндэсний зөвлөх эмч, багш нарыг гадаад болон дотоодод бэлтгэх	ЭМЯ	ЭМХТ, Улсын төв болон тусгай мэргэжлийн төв	2014-2016 тусгай Тушаал, тайлан

Бөөний өвлийн нийгэгүйн туслах, үйлчилгээг олон улсын түүхийг хургэх зорилтын хувь.

НУРСЭНДА:	Оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж, алгоритмыг олон улсын стандарт, удирдамжтай уялдуулан боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах	ЭМЯ, Клиникийн эмнэлгүүд	ОУБ Эмшиус эхэмүт	Жил бүр	Шинээр боловсруулсан стандартын тоо Хэрэгжилтийн тайлан
2	Бөөрний өвчиний талаар мөрдөгдөж байгаа стандарт, удирдамжийг тусгамж үйлчилгээнд хэрэглэх хэвшүүлэх ажлыг цогцоор хийх	ЭМЯ, Мэргэжлийн салбар зөвлөл	УНТЭ, мэргэжлийн төв Эмшиус, ТББ, мэргэжлийн нийтэмлэг, холбоод	2013-2016	Батлагдсан төлөвлөгөө ажлын тайлан
3	Бөөрний өвчин эмгэгийн оншилгоонд биопсийн шинжилгээг цогцоор нэвтрүүлэх /багаж, тоног төхөөрөмжөөр хангах, сургалт зохион байгуулах, стандарт мөрдүүлэх/	ЭМЯ	ОУБ Эмшиус Улсын төв болон тусгай мэргэжлийн төв, ЭСҮТ	2014 оноос	Тоног төхөөрөмж нийлүүлсэн байдал Хийгдсэн биопсийн тоо
4	Бөөрний төрөлжсөн, тусгай тусламж, үйлчилгээний чиглэлээр үндэсний зөвлөх эмч, багш нарыг гадаад болон дотоодод бэлтгэх	ЭМЯ	ЭМХТ, Улсын төв болон тусгай мэргэжлийн төв	2014-2016	Тушаал, шийдвэр, тайлан

5	Амаржих газруудад бөөрний эмчийн орон тоог амаржих газрын бүтэц, үйл ажиллагааны стандартад тусгах	ЭМЯ Аймаг, нийслэлийн газар эрүүл мэндийн газар	ЭМЯ ЭМХТ, Төв, тусгай мэргэжлийн төвүүд, ЭМШУИС	2014- 2018 Жил бүр	Тусгагдсан Бөөрний эмчийн тоо Сургалтын хөтөлбөр, тоо, тайлан	байдал,
6	Сүм, өрхийн эмч нар, ерөнхий мэргэжлийн, дотор, хуудийн, эх барих эмэгтэйчүүдийн эмч, мэргэжилтийн бөөрний өвчин эмгэгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр мэдлэг, чадварыг дээшүүлэх сургалтыг шаттайгаар тогтол явуулах	ЭМЯ ЭМХТ, Төв, тусгай мэргэжлийн төвүүд, ЭМШУИС	Жил бүр	Сургалтын хөтөлбөр, тоо, тайлан		
7	Бөөрний рашаан, сувилийг бүх талаар	ЭМЯ Мэргэжлийн салбар зөвлөл	Мэргэжлийн салбар зөвлөл	2014 оноос	Авсан хэмжээний тайлан	арга
8	Бөөрний өвчинтэй, бөөрний архаг дутагдалтай өвчтөний эмчилгээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баталгаат эмийг нэвтрүүлэх талаар судлах, эмийг бүртгүүлэх, нийлүүлэх, хэрэглэх арга хэмжээг авах	ЭМЯ, Мэргэжлийн салбар зөвлөл	ЭМБ, Эм ханган ниийлүүлэх байгууллагууд, мэргэжлийн нийгэмлэг, холбоод	2014- 2016 ханган	Бүртгүүлсэн, нэвтрүүлсэн, нийлүүлсэн тоо, тайлан	арга
9	Бөөр хамгаалах багц эмчилгээний үндсэн бэлдмэлгүүдийг хөнгөлөлтэй олгох эмийн жагсаалтандаа сүүлигэх талаар судлан холбогдох арга хэмжээг авах	ЭМЯ, Мэргэжлийн салбар зөвлөл	Нийгмийн хамгааллын яам Нийгмийн даатгалын өрөнхий газар	2014	Авсан хэмжээний тайлан	арга
10	Бөөрний чулуу өвчиний оношилгоо, эмчилгээнд орчин үеийн технологийг /экстракорпорал шээсний электролит үзэх/ тувшинд нарийвчлан судлах	ЭМЯ Технологийг питотрипси шээсний электролит үзэх/ тувшинд нарийвчлан судлах	УНТЭ, ОУБ, Төв, мэргэжлийн төвүүд, БОЭТ	2014 - 2018 Төв, мэргэжлийн төвүүд, БОЭТ	Нэвтрүүлсэн технологийн терөл, хэрэгжилт	арга
11	Бөөрний өвчин эмгэгийг эд, эс, генийн түвшинд нарийвчлан судлах	ЭМЯ Мэргэжлийн нийгэмлэг, холбоод	ШУТС Мэргэжлийн нийгэмлэг, холбоод	2015 - 2018 Төв	Судагааны тайлан, зөвлөмж	
3.1 Бөөр орлуулах эмчилгээний тусламж, үйлчилгээ						
12	Бөөр орлуулах эмчилгээнд эмнэлэгүйн болон эдийн застгийн үр ашигтай олон улсын тэргүүн туршлагыг ашиглалт, хүчин чадал гэх мэт/	Төв болон мэргэжлийн ЭМБ-үүд, ОУБ	Тусгай төв,	2014- 2018 Тусгай	Нэвтрэсэн үр ашигтай арга аргачлал	
13	Эрүүл мэндийн эрэпт хэрэгцээнд тулгуурлан	ЭМЯ, Төв Тусгай Мэргэжлийн	Тусгай Мэргэжлийн	2014-	Тайлан,	шинээр

14	гемодиализийн тасаг нэмж байгуулах, эмнэлэг перитонеаль диализийг хавсран хөгжүүлэх чадлыг бэхжүүлж, хүний нөөцийг чадавхижуулах	ЭМЯ, Тусгай мэргэжлийн төв эмнэлэг, БОЭТ	төв эмнэлэг, ЭМБ-үүд, ОУБ ЭМБ-үүд, ОУБ	2018-2018	байгуулагдсан тасийн тоо Тайлан
15	Диализийн мэргэжил аргазүйн судалгааны нэгдсэн төвийг улсын төв эмнэлэг дээр түшиглэн байгуулах	ЭМЯ УНТЭ	ЭМШУИС, Төв, тусгай мэргэжлийн төв эмнэлэг	2014-2018	Эрүүл мэндийн сайдын тушаал
16	Бөөрний өвчин эмгэгийн үйлдлийн стандартад бөөрний допплерт хэт авив харах, эдийн шинжилгээ авах талаар тусгах	ЭМЯ	СХЗГ, УНТЭ, ОУБ, Төв, мэргэжлийн төвүүд, БОЭТ	2014 оноос	Стандартад тусгагдсан байдал
17	Бөөр орлуулах эмчилгээний болон төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт, удирдамж боловсруулж баттуулах, хэрэгжүүлэх	ЭМЯ, УНТЭ, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг	СХЗГ, ОУБ	2013-2014	Стандартад тусгагдсан байдал
18	Бөөр орлуулах, бөөр шилжүүлэн суултаж эмчилгээний технологит үнэлгээ хийх	ЭМЯ	Мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоод	2015	Үнэлгээний тайлан
19	Бөөр шилжүүлэн суулгах мэс заслын үед хууль зүйн зөвлөгөө өгч, эрх зүйн зохицуулалт хийх ёс зүйн үндэсний зөвлөлийг байгуулах	ЭМЯ	ХЭЯ, Мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоод	2014 оноос	Ёс зүйн зөвлөл байгуулсан тушаал
20	Монгол Улсын Донорын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар судлах, арга хэмжээ авах	ЭМЯ	ХЭЯ, Мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоод	2014 оноос	Авсан арга хэмжээ
21	Цусны булагт өөр, эсрэг биеийн титр өндөр, В, С вирусын халдвартай хумууст бөөр шилжүүлэн суулгах эмчигтээг Монгол улсад хийх болопцоог судлан нэвтрүүлэх	ЭМЯ	ХЭЯ, Мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэг, холбоод	2014-2015	Хийсэн мэс заслын тоо Тоног төхөөрөмж, эмурвалжийн хангарт

4. Бөөрний өвчин эмгэгийн бүртгэл мэдээлэл, хяналт тандалт тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд:

1 Бөөрний өвчлөл, нас бааралтын тайлан мэдээнд ЭМЯ НЭМУТ 2013 Судалгааны

тархвар зүйн судалгаа хийх						
2	Бөөрний өвчтөний хяналтын өнөөгийн байдалц үнэлгээ өгч, шатлал тус бурд тохирсон аргачлал боловсруулах	ЭМЯ Хөтөлбөрийн баг	ЭМХТ Хөтөлбөрийн баг	2013	1. Элгээний тайлан, хяналтын тогтолцооны зөвлөмж	тайлан, зөвлөмж
3	Бөөрний өвчиний буртгэлийг өвчний олон улсын ангиллаар буртгэж байгаад үнэлгээ хийж, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт явуулах, сургач багш бэлтгэх	ЭМЯ Хөтөлбөрийн баг	ЭМХТ Хөтөлбөрийн баг	2013	Унэлгээний тайлан, зөвлөмж	
4	Бөөрний өвчин эмгэгт нөлөөлж буй шалтгааныг тогтоох судалгааг хийх	ЭМЯ Хөтөлбөрийн баг	ЭМХТ Хөтөлбөрийн баг	2014 оны 1-р улирал	Судалгааны тайлан, мэдээллийн сан Бүртгэл хяналтын тогтолцоо, ажиллах заавар, журам	
5	Бөөр хамгаалах, орлуулах, шилжүүлэн суулгах эмчилгээний Нэгдсэн бүртгэл, хяналтын тогтолцоог бий болгож, холбогдох заавар, журмыг боловсруулах	ЭМЯ Мэргэжлийн зөвлөл	ЭМХТ Мэргэжлийн салбар	2014 оны 3-р улиралд		
6	Бөөрний өвчин эмгэгтэй өвчтэй хүмүүсийг бүртгэх, хянах, дуудах журам боловсруулж мөрдүүлэх	ЭМЯ Хөтөлбөрийн баг	ЭМХТ Мэргэжлийн зөвлөл	2014 оны 3-р улиралд	Тушаал, шийдвэр	
7	Аймаг, дүүрэг, нийспээлийн статистикч их, бага эмч нарт сургалт зохион байгуулах	ЭМЯ Хөтөлбөрийн баг	ЭМХТ Хөтөлбөрийн баг	Жил бүр	Хөтөлбөр, удирдамж, тайлан	
8	Бөөрний эмгэгээс сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгийн алгоритмын дагуу авах мэдээний маягт, мэдээлэл авах журам боловсруулах, мэдээллийн сан үүсгэх	ЭМЯ баг	ЭМХТ, хөтөлбөрийн баг	2014 оноос	Авсан арга хэмжээний тайлан	
9	Хоёрдогч урьдчилан сэргийлэгт, дислансерийн хяналт, хүүхэд нааснаас насанд хурэгчдийн эмнэлэг шилжүүлэх журам, заавар боловсруулах	ЭМЯ Хөтөлбөрийн зөвлөл	Төв, мэргэжлийн эмнэлэг	2014 тусгай төв		
10	Бөөрний өвчтөл, нас баралтын статистик мэдээллийг бодлого боловсруулагч, шийдвэр хөтөлбөрийн багт улирал, жилээр цахим хэлбэрээр эргэн мэдээлэх арга хэмжээ авах	ЭМЯ Хөтөлбөрийн зөвлөл	ЭМХТ	2014 оноос	Тайлан	